# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр Дугаар А/614. Улаанбаатар хот

## Хан-Уул дүүргийн "Эко хотын тээвэр" ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.”Улаанбаатар хотын хүнсний хог хаягдал дахин боловсруулах төсөл”-ийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 46,035,000.00 (дөчин зургаан сая гучин таван мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Хан-Уул дүүргийн "Эко хотын тээвэр" ОНӨААТҮГ (Э.Эрдэнэчимэг)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн "Эко хотын тээвэр" ОНӨААТҮГ (Э.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУМАА

1150501838

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 13 -ны
өдрийн А/614 дугаар тушаалын хавсралт

## Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн "Эко хотын тээвэр" ОНӨААТҮГ

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Ашиглалтад авсан он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэлд авах | | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нэгжийн үнэ | Нийт үнэ | |
| 1 | Навч, хаягдал сорох машин | MAMUT PRO BT | 2024 | Шинэ | ш | 1 | 46,035,000.0 | 46,035,000.0 | Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл |
| **Нийт бүртгэх хөрөнгийн дүн** | | | | | | | | **46,035,000.0** | |